


ШҮҮХИЙН ХЭРГИЙН ХӨДӨЛГӨӨНИЙ УДИРДЛАГЫН МЭДЭЭ

2025 ОН 5 САР

№52

“ Шүүхийн ерөнхий зөвлөлийн Хэргийн хөдөлгөөний удирдлага, статистикийн газрын 2025 оны 5 дугаар сарын хэргийн хөдөлгөөний мэдээг нэгтгэн, улсын хэмжээн дэх эрүү, иргэн, захиргааны хэргийн анхан болон давж заалдах шатны шүүхүүдийн хэргийн хөдөлгөөний судалгааг танилцуулж байна. ”


ХҮЛЭЭН АВСАН ХЭРЭГ, НЭХЭМЖЛЭЛ



2025.05.01-2025.05.31-ний өдрийн байдлаар Улсын хэмжээн дэх анхан шатны шүүхүүд нийт **12156** хэрэг, нэхэмжлэл хүлээн авснаас эрүүгийн **1417**

хэрэг, иргэний **10435** нэхэмжлэл, захиргааны **304** нэхэмжлэл хүлээн авсан байна.


ХЯНАН ШИЙДВЭРЛЭСЭН ХЭРЭГ



2025.05.01-2025.05.31-ний өдрийн байдлаар Улсын хэмжээн дэх анхан шатны шүүхүүд нийт **9026** хэрэг хянан шийдвэрлэснээс эрүүгийн **1466**, иргэний **7279**, захиргааны **281**


хэрэг хянан шийдвэрлэсэн байна.

2025 ОНЫ 5 САРЫН БАЙДЛААРХ АНХАН ШАТНЫ ШҮҮХИЙН ХҮЛЭЭН АВСАН ХЭРЭГ, НЭХЭМЖЛЭЛИЙН МЭДЭЭ



ЭРҮҮГИЙН	ХЭРЭГ	ИРГЭНИЙ	ХЭРЭГ	ЗАХИРГААНЫ	ХЭРЭГ
Хүлээн авсан нийт хэрэг	Дүүргийн анхан шатны шүүх	Хүлээн авсан нийт нэхэмжлэл	Дүүргийн анхан шатны шүүх	Хүлээн авсан нийт нэхэмжлэл	Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүх
1417	651	10435	6616	304	196
	45.9%		63.4%		64.5%

АНХАН ШАТНЫ ШҮҮХИЙН ХҮЛЭЭН АВСАН ХЭРЭГ, НЭХЭМЖЛЭЛИЙН МЭДЭЭГ ӨМНӨХ ОНЫ МӨН ҮЕИЙНХТЭЙ ХАРЬЦУУЛБАЛ



Улсын хэмжээнд анхан шатны шүүхийн нийт хүлээн авсан хэрэг, нэхэмжлэлийн тоо өмнөх оны мөн үетэй харьцуулахад:

Иргэний нэхэмжлэл 2296 буюу 23.3 хувиар, Эрүүгийн хэрэг 33 буюу 2.3 хувиар тус тус нэмэгдсэн, Захиргааны нэхэмжлэл 57 буюу 2.3 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Дүүргийн анхан шатны шүүхүүдийн 2025 оны 5 дугаар сарын нэгдсэн тайлан мэдээнээс үзвэл Дүүргийн эрүү, иргэний хэргийн хялбар ажиллагааны тойргийн шүүх 3842 нэхэмжлэл, Баянгол, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны тойргийн шүүх 273 хэрэг, Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүх 196 нэхэмжлэл хүлээн авсан нь хамгийн өндөр үзүүлэлттэй гарсан байна.

Харин Багануур дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх 106 нэхэмжлэл, Багахангай, Налайх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх 23 эрүүгийн хэрэг, Дундговь болон Хэнтий аймгийн Захиргааны хэргийн шүүх тус бүр 1 нэхэмжлэл

хүлээн авсан нь хамгийн бага үзүүлэлттэй байна.

Орон нутаг дахь анхан шатны шүүхүүдийн хувьд Орхон аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх 325 нэхэмжлэл, Төв аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх 71 хэрэг, Хөвсгөл аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүх 11 нэхэмжлэл тус тус хүлээн авсан байгаа нь хамгийн өндөр үзүүлэлттэй байна.

Харин Ховд аймгийн Булган сум дахь сум дундын шүүх 37 нэхэмжлэл, Завхан аймгийн Тосонцэнгэл сум дахь сум дундын шүүх 6 эрүүгийн хэрэг, Хэнтий аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүх 1 нэхэмжлэл


хүлээн авсан бусад аймгуудтай харьцуулахад хамгийн бага үзүүлэлттэй байна.

Иргэний хэргийн шүүхийн хувьд хүлээн авсан нийт **10435** нэхэмжлэлийн **6616** буюу **63.4%**-ийг Дүүргийн анхан шатны шүүхүүд хүлээн авсан байна.


Захиргааны хэргийн шүүхийн хувьд хүлээн авсан нийт **304** нэхэмжлэлийн **196** буюу **64.5%**-ийг Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүх хүлээн авсан байна.

Эрүүгийн хэргийн шүүхийн хувьд хүлээн авсан нийт **1417** хэргийн **651** хэрэг буюу **45.9%**-ийг Дүүргийн анхан шатны шүүхүүд хүлээн авсан байна.

2025 ОНЫ 5 САРЫН БАЙДЛААРХ АНХАН ШАТНЫ ШҮҮХИЙН ХЯНАН ШИЙДВЭРЛЭСЭН ХЭРГИЙН МЭДЭЭ



АНХАН ШАТНЫ ШҮҮХИЙН ХЯНАН ШИЙДВЭРЛЭСЭН ХЭРГИЙН МЭДЭЭГ ӨМНӨХ ОНЫ МӨН ҮЕИЙНХТЭЙ ХАРЬЦУУЛБАЛ



Улсын хэмжээнд анхан шатны шүүхээр нийт хянан шийдвэрлэсэн хэргийн тоо өмнөх оны мөн үетэй харьцуулахад:

Эрүүгийн хэрэг 99 буюу 6.8 хувиар, Иргэний хэрэг 1637 буюу 22.3 хувиар, Захиргааны хэрэг 124 буюу 44.1 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

ШҮҮХ ХУРАЛДААН ХОЙШИЛСОН БАЙДАЛ



Иргэний хэргийн шүүхийн хувьд 6373 шүүх хуралдаан товлон зарласнаас 2681 шүүх хуралдаан хойшилсны 90% нь хэргийн оролцогчоос, 10% нь шүүхээс шалтгаалсан байна. Хэргийн оролцогч, тэдгээрийн итгэмжлэгдсэн төлөөлөгч, өмгөөлөгчтэй шүүх хуралдаанд оролцох, нотлох баримт гаргуулах хүсэлт гаргасан гэсэн шалтгаанаар шүүх хуралдаан хойшлуулсан нь хамгийн өндөр үзүүлэлттэй байна.

Захиргааны хэргийн шүүхийн хувьд 639 шүүх хуралдаан товлон зарласнаас 414 шүүх хуралдаан хойшилсны 92% нь хэргийн оролцогчоос, 8% нь шүүхээс шалтгаалсан байна. Хүсэлтийг хүлээн авч шүүх хуралдааныг хойшлуулсан гэсэн шалтгаан нь хамгийн өндөр үзүүлэлттэй байна.

Харин эрүүгийн хэргийн шүүхийн хувьд 1775 шүүх хурал товлон зарласнаас 743 шүүх хуралдаан хойшилсон 94.0% нь хэргийн оролцогчоос, 6% нь шүүхээс шалтгаалж хойшилсон.

Товлосон **8767**

НИЙТ ШҮҮХ ХУРАЛДААНЫ


Хойшилсон **3838**

43.7%


ХУГАЦАА ХЭТРЭЛТ

Улсын хэмжээнд хянан шийдвэрлэх ажиллагаанд нийт **20838** хэрэг байгаагаас **5535** хэрэг буюу **26.6%**-ийг хугацаа хэтэрсэн хэрэг эзэлж байна.


Иргэний хэргийн анхан шатны шүүхүүдийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд байгаа **18955** хэргийн **5304** хэрэг буюу **27.9%**, Захиргааны хэргийн анхан шатны шүүхүүдийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд байгаа **743** хэргийн **171** хэрэг буюу **23.1%**, Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхүүдийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд байгаа **1140** хэргийн **50** хэрэг буюу **4.4%** нь тус тус хугацаа хэтрэлттэй байна.



2025 ОНЫ 5 САРЫН БАЙДЛААРХ ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААНД БАЙГАА ХЭРЭГТ ХУГАЦАА ХЭТРЭЛТТЭЙ ХЭРЭГ




ТАСЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭ




Улсын хэмжээнд анхан шатны шүүх нийт 501 таслан сэргийлэх арга хэмжээний санал хүлээн авснаас 488 шийдвэрлэсэн байна. Үүнээс тодорхой үйл ажиллагаа явуулах, албан үүргээ биелүүлэхийг түдгэлзүүлэх 2, хязгаарлалт тогтоох 114, барьцаа авах 78, яллагдагчаар цагдан хорих 123, цагдан хорих хугацаа сунгах 167 арга хэмжээг хянан шийдвэрлэсэн байна.

ЗӨРЧЛИЙН ХЭРЭГ




Улсын хэмжээнд анхан шатны шүүх нийт 5887 зөрчлийн хэрэг хүлээн авснаас 5247 хэргийг шийдвэрлэсэн байна. Үүнээс торгох шийтгэл 3648, баривчлах шийтгэл 1686, эрх хасах шийтгэл 2187 хүн, хуулийн этгээдэд тус тус оногдуулсан байна. Харин нийтэд тустай ажил хийлгэх шийтгэлийг хүн, хуулийн этгээдэд оногдуулаагүй байна.

5 ДУГААР САРЫН АНХАН ШАТНЫ ШҮҮХИЙН НЭГДСЭН МЭДЭЭ



5 ДУГААР САРЫН ДАВЖ ЗААЛДАХ ШАТНЫ ШҮҮХИЙН НЭГДСЭН МЭДЭЭ


ХҮЛЭЭН АВСАН ХЭРЭГ, НЭХЭМЖЛЭЛ



2025.05.01-2025.05.31-ний өдрийн байдлаар Улсын хэмжээн дэх давж заалдах шатны шүүхүүд нийт **825** хэрэг, нэхэмжлэл хүлээн авснаас эрүүгийн **282**

хэрэг, иргэний **386** хэрэг, захиргааны **126** хэрэг, нэхэмжлэл хүлээн авсан байна.


ХЯНАН ШИЙДВЭРЛЭСЭН ХЭРЭГ



2025.05.01-2025.05.31-ний өдрийн байдлаар Улсын хэмжээн дэх давж заалдах шатны шүүхүүд нийт **786** хэрэг хянан шийдвэрлэснээс эрүүгийн **309**, иргэний **331**, захиргааны **146** хэрэг

хянан шийдвэрлэсэн байгаа нь өмнөх сартай харьцуулбал 0.8% өссөн үзүүлэлттэй байна.

ШҮҮХ ХУРАЛДААН ХОЙШИЛСОН БАЙДАЛ



Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн хувьд 408 шүүх хуралдаан товлон зарласнаас 66 шүүх хуралдаан хойшилсон. Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн хувьд 299 шүүх хуралдаан товлон зарласнаас 46 шүүх хуралдаан хойшилсон. Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн хувьд 218 шүүх хуралдаан товлон зарласнаас 80 шүүх хуралдаан тус тус хойшилсон байна.

ХУГАЦАА ХЭТРЭЛТ

Улсын хэмжээнд хянан шийдвэрлэх ажиллагаанд нийт **466** хэрэг байгаагаас **31** хэрэг буюу **6,7%**-ийг хугацаа хэтэрсэн хэрэг эзэлж байна.

Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхүүдийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд байгаа **222** хэргийн **5** хэрэг буюу **0.9%**, Эрүүгийн хэргийн давж заалдах шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллаганд байгаа **112** хэргийн **3** хэрэг буюу **2.6%**, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд байгаа **132** хэргийн **23** хэрэг буюу **17.4%** тус тус хугацаа хэтэрсэн байна.



«ХЭРГИЙН ХӨДӨЛГӨӨНИЙ АРГАЧЛАЛ БОЛОН СТАТИСТИК, ТҮҮНТЭЙ ХОЛБООТОЙ ДҮРЭМ, ЖУРМЫН ХЭРЭГЖИЛТ» СЭДВЭЭР СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАВ.

2025 оны 5 дугаар сарын 06-07-ны өдрүүдэд Баяндөхөм сургалтын төвд Иргэн, Эрүү, Захиргааны хэргийн хөдөлгөөний нийтлэг аргачлал, түүнд хэрэглэгдэх баримтын загварт орсон өөрчлөлт, онцлог, хэрэгжүүлэхэд анхаарах асуудал болон статистик, түүнтэй холбоотой журам, дүрэм, хэрэгжилтийн талаар Хэргийн хөдөлгөөний хэлтсийн дарга, Шүүхийн зохион байгуулалтын хэлтсийн дарга дарга нарт хичээл орлоо.

